

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/161/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг  
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

Аудитор С.Оргил  
Утас: 77665858

Цахим хаяг: [Info@shinjenmagadlakhui-audit.mn](mailto:Info@shinjenmagadlakhui-audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.07.25 № 23  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН  
ХҮҮХДИЙН 8 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Ж.ЭНХСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 8-р цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,024,399.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,000,987.2 мянган төгрөгийг зарцуулж 23,412.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 110 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт                              | Өмнөх он        | Тайлант он       |
|-----|---------------------------------------|-----------------|------------------|
| 1   | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН               | 160,653,158.26  | 81,448,101.56    |
| 2   | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ     | 122,889,309.70  | 23,412,444.50    |
| 8   | Банканд байгаа бэлэн мөнгө            | 122,889,309.70  | 23,412,444.50    |
| 9   | Төгрөг                                | 122,889,309.70  | 23,412,444.50    |
| 10  | Төрийн сангийн харилцах               | 122,889,309.70  | 23,412,444.50    |
| 60  | БАРАА МАТЕРИАЛ                        | 37,763,848.56   | 58,035,657.06    |
| 61  | Түүхий эд материал                    | -               | 179,846.30       |
| 63  | Эм боох материал                      | -               | 179,846.30       |
| 66  | Хангамжийн материал                   | 37,763,848.56   | 57,855,810.76    |
| 67  | Бичиг хэргийн материал                | 367,000.00      | 4,856,404.00     |
| 68  | Аж ахуйн материал                     | 36,912,848.56   | 40,931,306.76    |
| 71  | Барилгын засварын материал            | 484,000.00      | 3,354,600.00     |
| 72  | Хүнсний материал                      | -               | 2,640,000.00     |
| 73  | Бусад хангамжийн материал             | -               | 6,073,500.00     |
| 86  | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН           | 375,340,309.26  | 391,971,978.80   |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                        | 375,340,309.26  | 391,971,978.80   |
| 108 | Биет хөрөнгө                          | 345,601,559.26  | 352,161,978.80   |
| 109 | Барилга, байгууламж                   | 348,976,982.44  | 346,372,982.44   |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл                 | (51,595,629.30) | (61,945,421.58)  |
| 113 | Машин, тоног төхөөрөмж                | 84,806,296.80   | 70,236,234.30    |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл                 | (42,373,111.28) | (31,832,851.78)  |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил           | 33,696,146.18   | 33,770,395.26    |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл                 | (29,854,026.38) | (6,384,260.64)   |
| 125 | Номын фонд                            | 1,944,900.80    | 1,944,900.80     |
| 126 | Биет бус хөрөнгө                      | 29,738,750.00   | 39,810,000.00    |
| 127 | Программ хангамж                      | 2,117,500.00    | 2,117,500.00     |
| 128 | Хасагдуулаг                           | (1,828,750.00)  | (1,237,500.00)   |
| 129 | Бусад биет бус хөрөнгө                | 29,450,000.00   | 38,930,000.00    |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН                    | 535,993,467.52  | 473,420,080.36   |
| 138 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН                 | 800,000.00      | 57,432,000.00    |
| 139 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР             | 800,000.00      | 57,432,000.00    |
| 164 | Өглөг                                 | 800,000.00      | 57,432,000.00    |
| 170 | Бусад өглөг                           | 800,000.00      | 57,432,000.00    |
| 171 | Байгууллагад төлөх өглөг              | 800,000.00      | 57,432,000.00    |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН              | 535,193,467.52  | 415,988,080.36   |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо           | 535,193,467.52  | 415,988,080.36   |
| 223 | Хуримтлагдсан үр дүн                  | 90,529,675.08   | (28,675,712.08)  |
| 224 | Өмнөх үеийн үр дүн                    | 90,529,675.08   | 90,529,675.08    |
| 225 | Тайлант үеийн үр дүн                  | -               | (119,205,387.16) |
| 227 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү      | 87,742,745.01   | 87,742,745.01    |
| 230 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 356,921,047.43  | 356,921,047.43   |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН   | 535,993,467.52  | 473,420,080.36   |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

| Код     | Үзүүлэлт                                                             | ӨМНӨХ ОН       | ТАЙЛАНТ ОН       |
|---------|----------------------------------------------------------------------|----------------|------------------|
| I       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                                      | 972,149,300.00 | 1,043,409,417.28 |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                                  | 18,937,500.00  | 54,620,117.28    |
| 120     | Нийтлэг татварын бус орлого                                          | 18,937,500.00  | 54,620,117.28    |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого                                     | 18,937,500.00  | 43,005,167.28    |
| 1200042 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 140,000.00     | 175,000.00       |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө                   | 18,797,500.00  | 42,830,167.28    |
| 120011  | Борлуулалтын өртөг /ТӨҮГ/                                            | -              | 11,614,950.00    |
| 13      | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                        | 953,211,800.00 | 988,789,300.00   |
| 1310    | Улсын төвлөрсөн төсвөөс                                              | 874,826,700.00 | 914,743,800.00   |
| 131001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    | 874,826,700.00 | 914,743,800.00   |
| 1320    | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                       | 78,385,100.00  | 74,045,500.00    |
| 132001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 78,385,100.00  | 74,045,500.00    |
| II      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                                          | 918,025,992.27 | 1,160,010,804.44 |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ                                                        | 918,025,992.27 | 1,160,010,804.44 |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                      | 910,966,228.21 | 1,154,732,702.03 |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                    | 624,029,953.55 | 789,530,300.00   |
| 210101  | Үндсэн цалин                                                         | 426,642,532.22 | 525,536,802.34   |
| 210102  | Нэмэгдэл                                                             | 168,868,565.46 | 236,049,587.79   |
| 210104  | Урамшуулал                                                           | 28,518,855.87  | 27,943,909.87    |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                       | 81,793,400.00  | 91,639,200.00    |
| 210201  | Тэтгэврийн даатгал                                                   | 55,619,600.00  | 62,593,000.00    |
| 210202  | Тэтгэмжийн даатгал                                                   | 6,543,400.00   | 7,332,300.00     |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал                                                    | 3,271,700.00   | 3,667,300.00     |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал                                                 | 3,271,700.00   | 3,395,100.00     |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал                                                | 13,087,000.00  | 14,651,500.00    |
| 2103    | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                            | 61,075,335.94  | 116,271,797.59   |
| 210301  | Гэрэл, цахилгаан                                                     | 7,379,995.00   | 10,294,872.00    |
| 210302  | Түлш, халаалт                                                        | 48,858,167.00  | 48,000,000.00    |
| 210303  | Цэвэр, бохир ус                                                      | 4,837,173.94   | 5,476,925.59     |
| 210304  | Байрны түрээс                                                        | -              | 52,500,000.00    |
| 2104    | Хангамж, бараа материалын зардал                                     | -              | 5,541,450.00     |
| 210406  | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | -              | 5,541,450.00     |
| 2105    | Норматив зардал                                                      | 90,619,079.20  | 100,159,445.70   |
| 210502  | Хоол, хүнс                                                           | 90,619,079.20  | 100,159,445.70   |
| 2106    | Эд хогшил, урсгал засварын зардал                                    | 7,646,000.00   | 7,192,500.00     |
| 210604  | Урсгал засвар                                                        | 7,646,000.00   | 7,192,500.00     |
| 2108    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 2,840,000.00   | 3,090,400.00     |
| 210806  | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 2,840,000.00   | 3,090,400.00     |
| 2109    | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 42,962,459.52  | 41,307,608.74    |
| 210901  | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 21,771,405.00  | 11,704,111.00    |
| 210902  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 150,000.00     | 3,734,000.00     |
| 210903  | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   | 21,041,054.52  | 25,869,497.74    |
| 213     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                                     | 7,059,764.06   | 5,278,102.41     |
| 2134    | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 7,059,764.06   | 5,278,102.41     |
| 213403  | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                | 7,059,764.06   | 5,278,102.41     |
| III     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)                                   | 54,123,307.73  | (116,601,387.16) |
| 225     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                                      | -              | 2,604,000.00     |
| 225001  | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                                       | -              | 2,604,000.00     |
| IV      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)                             | -              | (2,604,000.00)   |
| V       | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)                                              | 54,123,307.73  | (119,205,387.16) |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

| Код     | Үзүүлэлт                                                             | ӨМНӨХ ОН       | ТАЙЛАНТ ОН       |
|---------|----------------------------------------------------------------------|----------------|------------------|
| 1       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)                               | 953,351,800.00 | 988,964,300.00   |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                                  | 140,000.00     | 175,000.00       |
| 120     | Нийтлэг татварын бус орлого                                          | 140,000.00     | 175,000.00       |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого                                     | 140,000.00     | 175,000.00       |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 140,000.00     | 175,000.00       |
| 13      | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                        | 953,211,800.00 | 988,789,300.00   |
| 1310    | Улсын төвлөрсөн төсвөөс                                              | 874,826,700.00 | 914,743,800.00   |
| 131001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    | 874,826,700.00 | 914,743,800.00   |
| 1320    | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                       | 78,385,100.00  | 74,045,500.00    |
| 132001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 78,385,100.00  | 74,045,500.00    |
| 2       | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)                                | 895,582,579.75 | 1,086,166,165.20 |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ                                                        | 895,582,579.75 | 1,086,166,165.20 |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                      | 888,522,815.69 | 1,080,888,062.79 |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                    | 624,029,953.55 | 789,530,300.00   |
| 210101  | Үндсэн цалин                                                         | 426,642,532.22 | 525,536,802.34   |
| 210102  | Нэмэгдэл                                                             | 168,868,565.46 | 236,049,587.79   |
| 210104  | Урамшуулал                                                           | 28,518,855.87  | 27,943,909.87    |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                       | 81,793,400.00  | 91,639,200.00    |
| 210201  | Тэтгэврийн даатгал                                                   | 55,619,600.00  | 62,320,800.00    |
| 210202  | Тэтгэмжийн даатгал                                                   | 6,543,400.00   | 7,332,300.00     |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал                                                    | 3,271,700.00   | 3,667,300.00     |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал                                                 | 3,271,700.00   | 3,667,300.00     |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал                                                | 13,087,000.00  | 14,651,500.00    |
| 2103    | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                            | 61,075,335.94  | 63,771,797.59    |
| 210301  | Гэрэл, цахилгаан                                                     | 8,238,162.00   | 10,294,872.00    |
| 210302  | Түлш, халаалт                                                        | 48,000,000.00  | 48,000,000.00    |
| 210303  | Цэвэр, бохир ус                                                      | 4,837,173.94   | 5,476,925.59     |
| 2105    | Нормативт зардал                                                     | 91,074,203.20  | 102,799,445.70   |
| 210502  | Хоол, хүнс                                                           | 91,074,203.20  | 102,799,445.70   |
| 2106    | Эд хогшил, урсгал засварын зардал                                    | 7,646,000.00   | 4,995,600.00     |
| 210604  | Урсгал засвар                                                        | 7,646,000.00   | 4,995,600.00     |
| 2108    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 2,840,000.00   | 3,090,400.00     |
| 210806  | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 2,840,000.00   | 3,090,400.00     |
| 2109    | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 20,063,923.00  | 25,061,319.50    |
| 210901  | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 14,197,523.00  | 16,697,119.50    |
| 210902  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 5,866,400.00   | 8,364,200.00     |
| 213     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                                     | 7,059,764.06   | 5,278,102.41     |
| 2134    | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 7,059,764.06   | 5,278,102.41     |
| 213403  | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                | 7,059,764.06   | 5,278,102.41     |
| 3       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)                     | 57,769,220.25  | -97,201,865.20   |

|        |                                                                     |                |                |
|--------|---------------------------------------------------------------------|----------------|----------------|
| 5      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)                           | 10,604,000.00  | 2,275,000.00   |
| 22     | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                                    | 10,604,000.00  | 2,275,000.00   |
| 2200   | Дотоод эх үүсвэрээр                                                 | 10,604,000.00  | 2,275,000.00   |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                      | 10,604,000.00  | 2,275,000.00   |
| 6      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -10,604,000.00 | -2,275,000.00  |
| 8      | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)                           | 47,165,220.25  | -99,476,865.20 |
| 9      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                    | 75,724,089.45  | 122,889,309.70 |
| 10     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                   | 122,889,309.70 | 23,412,444.50  |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт                              | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-----------------------------------------|
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 356,921,047.43                  | 87,742,745.01         | 90,529,675.08     | 535,193,467.52                          |
| D01 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 356,921,047.43                  | 87,742,745.01         | 90,529,675.08     | 535,193,467.52                          |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 356,921,047.43                  | 87,742,745.01         | 90,529,675.08     | 535,193,467.52                          |
| D08 | Тайлант үеийн үр дүн                  | 00.00                           | 00.00                 | -                 | -                                       |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 356,921,047.43                  | 87,742,745.01         | -28,675,712.08    | 415,988,080.36                          |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | ҮЗҮҮЛЭЛТ                                       | ТӨЛӨВЛӨГӨӨ              | ГҮЙЦЭТГЭЛ               | Зөрүү           | Хувь   |
|-----|------------------------------------------------|-------------------------|-------------------------|-----------------|--------|
| 2   | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН           | <b>1,098,445,100.00</b> | <b>1,083,163,062.79</b> | 15,282,037.21   | 98.61  |
| 3   | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН                             | 1,098,445,100.00        | 1,083,163,062.79        | 15,282,037.21   | 98.61  |
| 4   | Бараа, үйлчилгээний зардал                     | 1,098,445,100.00        | 1,083,163,062.79        | 15,282,037.21   | 98.61  |
| 5   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил              | 789,530,300.00          | 789,530,300.00          | -               | 100.00 |
| 6   | Үндсэн цалин                                   | 527,962,600.00          | 525,536,802.34          | 2,425,797.66    | 99.54  |
| 7   | Нэмэгдэл                                       | 247,306,100.00          | 236,049,587.79          | 11,256,512.21   | 95.45  |
| 9   | Урамшуулал                                     | 14,261,600.00           | 27,943,909.87           | (13,682,309.87) | 195.94 |
| 11  | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 98,180,400.00           | 91,639,200.00           | 6,541,200.00    | 93.34  |
| 12  | Тэтгэврийн даатгал                             | 66,599,300.00           | 62,320,800.00           | 4,278,500.00    | 93.58  |
| 13  | Тэтгэмжийн даатгал                             | 7,895,300.00            | 7,332,300.00            | 563,000.00      | 92.87  |
| 14  | ҮОМШӨ ний даатгал                              | 3,947,600.00            | 3,667,300.00            | 280,300.00      | 92.90  |
| 15  | Ажилгүйдлийн даатгал                           | 3,947,600.00            | 3,667,300.00            | 280,300.00      | 92.90  |
| 16  | Эрүүл мэндийн даатгал                          | 15,790,600.00           | 14,651,500.00           | 1,139,100.00    | 92.79  |
| 17  | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал      | 69,045,500.00           | 63,771,797.59           | 5,273,702.41    | 92.36  |
| 18  | Гэрэл цахилгаан                                | 12,084,100.00           | 10,294,872.00           | 1,789,228.00    | 85.19  |
| 19  | Түлш, халаалт                                  | 48,000,000.00           | 48,000,000.00           | -               | 100.00 |
| 20  | Цэвэр, бохир ус                                | 8,961,400.00            | 5,476,925.59            | 3,484,474.41    | 61.12  |
| 30  | Норматив зардал                                | 104,803,900.00          | 102,799,445.70          | 2,004,454.30    | 98.09  |
| 32  | Хоол, хүнс                                     | 104,803,900.00          | 102,799,445.70          | 2,004,454.30    | 98.09  |
| 34  | Эд хогшил худалдан авах                        | 5,000,000.00            | 4,995,600.00            | 4,400.00        | 99.91  |

|     |                                                   |                         |                       |                  |        |
|-----|---------------------------------------------------|-------------------------|-----------------------|------------------|--------|
| 38  | Урсгал засвар                                     | 5,000,000.00            | 4,995,600.00          | 4,400.00         | 99.91  |
| 43  | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр   | 4,527,200.00            | 3,090,400.00          | 1,436,800.00     | 68.26  |
| 49  | Мэдээллийн технологийн зардал                     | 4,527,200.00            | 3,090,400.00          | 1,436,800.00     | 68.26  |
| 53  | Бараа үйлчилгээний бусад зардал                   | 27,357,800.00           | 27,336,319.50         | 21,480.50        | 99.92  |
| 54  | Бараа үйлчилгээний бусад зардал                   | 18,993,600.00           | 18,972,119.50         | 21,480.50        | 99.89  |
| 55  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                 | 8,364,200.00            | 8,364,200.00          | -                | 100.00 |
| 97  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>             | <b>1,098,445,100.00</b> | <b>983,686,197.59</b> | 114,758,902.41   | 89.55  |
| 98  | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                           | 1,024,224,600.00        | 914,743,800.00        | 109,480,800.00   | 89.31  |
| 99  | Улсын төсвөөс санхүүжих                           | 1,024,224,600.00        | 914,743,800.00        | 109,480,800.00   | 89.31  |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                    | 74,045,500.00           | 68,767,397.59         | 5,278,102.41     | 92.87  |
| 104 | Орон нутгийн төсвөөс                              | 74,045,500.00           | 68,767,397.59         | 5,278,102.41     | 92.87  |
| 110 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС             | 175,000.00              | 175,000.00            | -                | 100.00 |
| 112 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих         | 175,000.00              | 175,000.00            | -                | 100.00 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -                       | 122,889,309.70        | (122,889,309.70) | -      |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -                       | 23,412,444.50         | (23,412,444.50)  | -      |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                  | -                       | -                     | -                | -      |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО                                  | 1.00                    | 1.00                  | -                | 100.00 |
| 131 | Төсвийн байгууллага                               | 1.00                    | 1.00                  | -                | 100.00 |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО                                   | 25.00                   | 25.00                 | -                | 100.00 |
| 134 | Удирдах ажилтан                                   | 1.00                    | 1.00                  | -                | 100.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан                                 | 14.00                   | 14.00                 | -                | 100.00 |
| 136 | Үйлчлэх ажилтан                                   | 10.00                   | 10.00                 | -                | 100.00 |
| 138 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/                | 207.00                  | 207.00                | -                | 100.00 |
| 142 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага          | 207.00                  | 207.00                | -                | 100.00 |
| 143 | Төрийн өмчит СӨБ байгууллага                      | 207.00                  | 207.00                | -                | 100.00 |
| 148 | ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО                                | -                       | -                     | -                | -      |

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулаагүй 6,176.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, 5,001.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,175.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, шилэн данстай холбоотой 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 6,176.9 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 13,050.1 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

##### 3.1.1. Цалинтай холбоотой:

**Илрүүлэлт:** Тус цэцэрлэгийн эрхлэгчид ээлжийн амралтын 8 хоногийн 1,175,816.8 төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

#### 3.2 Албан шаардлага

##### 3.2.1. Худалдан авалттай холбоотой:

**Илрүүлэлт:** Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5,001,046.3 төгрөгийн бараа материалын худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

|                                   | Төлбөрийн акт |                | Албан шаардлага |                | Зөвлөмж  |                | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|-----------------------------------|---------------|----------------|-----------------|----------------|----------|----------------|--------------------------------------|-----|-------------------------------------------------|-----|
|                                   | Тоо           | Дүн            | Тоо             | Дүн            | Тоо      | Дүн            | Тоо                                  | Дүн | Тоо                                             | Дүн |
| Цахим худалдан авалттай холбоотой | 1             | 5,001.0        |                 |                | 1        | 5,001.0        |                                      |     |                                                 |     |
| Цалинтай холбоотой                | 1             | 1,175.8        | 1               | 1,175.8        |          |                |                                      |     |                                                 |     |
| <b>Дүн</b>                        | <b>2</b>      | <b>6,176.9</b> | <b>-</b>        | <b>1,175.8</b> | <b>1</b> | <b>5,001.0</b> | <b>-</b>                             |     |                                                 |     |

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |     | Үүнээс          |     | Зөвлөмж |     |
|----------------------------------------------------------|-------------|-----|-----------------|-----|---------|-----|
|                                                          |             |     | Албан шаардлага |     |         |     |
|                                                          | Тоо         | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |     |                 |     |         |     |
| 2 мэдээлэл хоцорч мэдээлсэн                              | 1           |     |                 |     | 1       |     |
| Дүн                                                      | 1           |     |                 |     | 1       |     |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |     |                 |     |         |     |
|                                                          |             |     |                 |     |         |     |
| Дүн                                                      |             |     |                 |     |         |     |
| Нийт дүн                                                 |             |     |                 |     |         |     |

